



Mongolia:  
Enhancing Resource  
Management through  
Institutional Transformation

Санхүүгийн ур чадвар

# Хувийн хэвшлийн ба төрийн санхүүг харьцуулах нь I

Хувийн хэвшлийн ба төрийн санхүүгийн менежмент нь дараах 4 хүрээгээр ялгаатай. Үүнд:

## • Байгууллагын зорилго

- Хувийн компаниуд ашгаа аль болох их байлгахыг чармайдаг бол төрийн алба үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн байдаг. Энэ нь төрийн албаны төсөв голдуу өсөн нэмэгддэг, бүхий л шатанд нь зардал танах хандлагатай байдаг гэсэн үг.

## • Шийдвэр гаргах үйл явц

- Хувийн хэвшилд хөрөнгө санхүүгийн шийдвэрийг ерөнхийдөө дээрээс доош чиглэлтэй гаргадаг. Харин төрийн албаны хувьд уг шийдвэрт гадаад, дотоод орчны олон оролцогч тал болон олон нийт оролцдог.

# Хувийн хэвшлийн ба төрийн санхүүг харьцуулах нь II

## • Нягтлан бодох бүртгэл

- Хувийн компаниуд ихэвчлэн санхүү бүртгэлийн илүү чанга дүрэм журам, шаардлагыг дагаж мөрддөг. Ийм адил арга практикыг төрийн байгууллагад ашиглаж болох хэдий ч заавал дагаж мөрдөхийг хатуу шаардахгүй байх нь олонтоо.

## • Агуулга

- Хувийн хэвшилд төсөв санхүүгийн менежер хүн хурдан гавшгай, мэдрэмжтэй, байгууллагаа ашигтай байлгахын тулд заримдаа бүр чанга хатуу байх ч шаардлага гардаг. Харин төрийн албанд төсөв санхүүгийн менежерийг дипломат, сэтгэлгээний хувьд уян хатан, маш шаргуу байх хэрэгтэй болдог.

# Төсөв санхүүгийн эрхшээл

- Төсөв хүрэлцэхгүй байх нь өнөөдөр төрийн үйлчилгээнд тохиолдож буй нийтлэг дүр төрх юм.
- Энэ нь төрийн албан хаагчид нэгэн зэрэг илүү хариуцлагатай, бас илүү үр дүнтэй ажиллах ёстойг харуулж байна.
- Энэ зорилгод шинэчлэл ба инновацийг хослуулан хийх замаар л хүрч болно.

# Үр дүнд суурилсан төсөвлөлт (ҮДСТ)

- 2012 оноос 2014 оны хооронд Альберта мужийн Засгийн газар тус мужийн 700 гаруй хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, тэдгээрийн үр дүн болон үр ашгийг үнэлж дүгнэхэд ҮДСТ-ийг ашиглахаар шийдсэн.
- Энэхүү ҮДСТ нь адил төстэй болон үр дүн нь харилцан хамаарал бүхий хөтөлбөр, үйлчилгээнүүдийг сэдэвчлэн бүлэглэсэн үйл ажиллагааны 11чиглэл (ҮАЧ)-д тулгуурлаж байв.
- Ийнхүү төсөвлөх үйл явцад илүү цогц, оролцоог хангасан байдлаар хандсанаар маш олон эерэг үр дагавар (хүмүүс илүү нэгдэж нягтрах, ойлголцол нэмэгдэх, харилцаа холбоо сайжрах зэрэг) авчирсан төдийгүй цаашлаад үр дүнд төвлөрөх байгууллагын 'сэтгэлгээ' бий болох эхлэлийг тавьжээ.

# Авсан сургамж

- *ҮДСТ-ийн үйл явц өөрөө сорилт юм:*
  - Цаг хугацааны хувьд шахуу байсан;
  - ҮДСТ-ийн зорилгын талаар бүдүүн тойм ойлголттой байсан;
  - Хөтөлбөрийг үнэлэх туршлага хүн бүрд байгаагүй.
- *Яамд хоорондын хамтын ажиллагааны үр дүнд:*
  - Харгалзах ҮАЧ дэх хөтөлбөр, үйлчилгээ хоорондын харилцаа, уялдаа холбооны талаар ойлголт дээшилсэн. Ингэснээр янз бүрийн багцын удирдлага сайжрахад хүргэсэн;
  - Ирээдүйд илүү ойр ажиллаж, ажлаа уялдуулахад нь нэмэр болохуйц урт хугацааны харилцаа, хэлхээ холбоог хөгжүүлсэн.
  - Гол төлөв өөр өөр яамдаас оролцсон ялгаатай хяналтын нэгжүүдийн хоорондох хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжсэн.

- *Өөрчлөлтийн соёл*: ҮДСТ-ийн үйл явц нь үнэ цэнтэй бөгөөд удаан хугацаанд хадгалагдах олон үр өгөөжийг авчирсан.
  - Оролцогчид үйл ажиллагааны нийтлэг чиглэлүүдийг холбож, удирдах боломжийг ойлгож, талархан хүлээж авч байсан бөгөөд энэ нь хамгийн сайн үр дүнд хүрэхэд тохирох арга барил болох нь тодорхой харагдсан.
  - Оролцогчдын дунд, ялангуяа ҮДСТ-ийн ажлын хэсэгт багтсан гишүүдэд хандлага болон сэтгэлгээний өөрчлөлт гарсан.
  - Төрийн байгууллагууд “нэгэн бүхэл болж” ажиллах хандлага ажиглагдах болсон.

# Ухаалаг зохицуулалт

- Европын холбоо 2010 онд “Ухаалаг зохицуулалт гэдэг нь илүү олон эсвэл цөөн тооны зохицуулалттай байх тухай огт биш, харин хамгийн төвөггүй арга замаар үр дүн гаргах тухай ойлголт юм” хэмээн тодорхойлжээ.
- Австралийн загвар нь иргэдийн аюулгүй байдлыг хязгаарлалгүйгээр төрийн дарамт шахалтыг бууруулахад голлон анхаардаг.
  - Дүрэм журмыг үнэлэх үнэлгээний арга хэрэгслийг боловсруулан гаргасан. Шинэ дүрэм журам төлөвлөгдөж дуусмагц үүнийг ашиглан үнэлж байхыг шаарддаг.
  - Үйл явцыг илүү үр дүнтэй болгохын тулд газар болгонд ажилладаг мэргэжилтнүүдээс бүрдэх “шинжээчийн” багийг бий болгосон.
  - Дүрэм журмын алийг нь хүчингүй болгох, нэгтгэх, хялбаршуулбал зохихыг үнэлэхийн тулд жил бүр дүрэм журмуудад аудит хийдэг.



# Стратегийн худалдан авалт

- Стратегийн худалдан авалт бол төрийн худалдан авалтыг эдийн засгийн хөгжил ба инновацийг түргэтгэх хөшүүрэг болгон ашиглах арга хандлага юм.
- Стратегийн худалдан авалт нь худалдан авалтыг стратегийн үр дүнд хүргэх хэрэгсэл болгон ашиглана гэсэн үг. Эдгээр нь тактикийн төслүүдээс хавьгүй илүү мэдлэг, чадавх, хамтын ажиллагаа болон эрх мэдлийг агуулдаг томоохон төслүүд байх хандлагатай.
- Стратегийн худалдан авалт нь бүх оролцогч тал илүү хамтран ажиллаж, стратегийн чиг үүрэгт түлхүү төвлөрөхийг шаардана.